



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

МОНГОЛЫН НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА – 2021



УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

1. НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	4
2. НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД	4
3. НООЛУУРАН ТҮҮХИЙ ЭДИЙН НӨӨЦ	6
4. НООЛУУРАН ТҮҮХИЙ ЭДИЙН БЭЛТГЭЛ.....	9
5. НООЛУУРАН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	11
6. НООЛУУРЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.....	14
7. НООЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ХҮЧИН ЧАДАЛ АШИГЛАЛТ	14
8. НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ	15
9. НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЭКСПОРТ	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 3.1. Малын тоо, төрлөөр, мян.толгой	6
Хүснэгт 3.2. Ямааны тоо 2016-2021 он, мян.толгой.....	8
Хүснэгт 4.1. 2021 оны ноолуур бэлтгэлийн тооцоо	9
Хүснэгт 4.2. Ноолуур бэлтгэлийн хэмжээ, тн, 2015-2021 он	10
Хүснэгт 5.1. Ноолуурын үнэ, төгрөг, 2020-2021 он	13
Хүснэгт 6.1. Ноолуурын салбарын хөрөнгө оруулалт.....	14
Хүснэгт 8.1. Ноолуурын салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 2010-2021 он	16
Хүснэгт 9.1. Ноолууран бүтээгдэхүүний экспорт, улсаар, мянган ам.доллаароор	16
Хүснэгт 9.2. Ноолууран бүтээгдэхүүний экспорт, улсаар, мянган ам.доллаароор.....	18
Хүснэгт 9.3. Ноолууран бүтээгдэхүүний экспорт, улсаар, мянган ам.доллаароор, 2018-2021 он	19
Хүснэгт 9.4. Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын экспорт, мян.ам.доллар	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Ноолуурын үйлдвэрийн салбарын танилцуулга.....	4
Зураг 2.1. Ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарт төрөөс баримтлах бодлого.....	5

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 3.1. Нийт малын тоонд малын төрөл тус бүрийн эзлэх хувийн жин, 1970-2019 он.....	7
График 3.2. Аймаг болон бүсүүдийн ямааны тоо, 2021 он, мян.толгой.....	8
График 4.1. Ноолуур ашиглалтын харьцаа, мян.тн.....	10
График 5.1. Дэлхийн зах зээл дээрх ноолуурын үнэ	11
График 7.1. Ноолуурын үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал, технологийн дамжлагаар	15
График 7.2. Ноолуурын үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал ашиглалт.....	15
График 8.1. Нэг хүнд ногдох угаасан ноос, самнасан ноолуур үйлдвэрлэл, килограммаар	16
График 9.1. Ноолуурын экспорт, улс орноор, хувиар.....	17


1. НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Дэлхийн ноолуурын зах зээл жилд дунджаар 24 мянган тонн ноолуур үйлдвэрлэдэг бөгөөд үүний 50 хувийг (12 мянган тонн) Хятад улс дангаараа хангадаг бол Монгол Улс 40 хувийг (9,6 мянган тонн) нийлүүлдэг. Ноолуур боловсруулах чиглэлээр Итали, Их Британи тэргүүлдэг¹.

Ноолууран ширхэгт нь байгалиас нано бүтэцтэй учраас дээд зэргийн зөөлөн, хөнгөн, дулаан, уян хатан, бөх бат, амьсгалдаг, агаар шүүдэг, галд тэсвэртэй, байгальд задардаг зэрэг хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй үзүүлэлтээрээ ноолууран бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн түвшингийн дундаас дээш болон тансаг хэрэглээний бүлгийнхний хэрэгцээт бүтээгдэхүүн болж, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд эрэлттэй хэвээр байна.

Ноолуур боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 үйл ажиллагаа явуулж, угаасан ноолуурыг БНХАУ, самнасан ноолуурыг Итали, Их Британи, БНХАУ, БНСУ, ХБНГУ, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Белги, Франц зэрэг 35 оронд экспортолж байна.

Зураг 1.1 Ноолуурын үйлдвэрийн салбарын танилцуулга



Нийт салбарт ажиллагсдын тоо 10,000, үүнээс 90% нь эмэгтэйчүүд
25% нь 45-аас дээш насныхан, 75% нь залуучууд байна

Үндэсний статистикийн хорооны 2021 оны мэдээгээр 10.1 мян.тн ноолуур бэлтгэж, 2,235.2 тн ноолуур угааж, 511.7 тн ноолуур самнаж, 215.0 тн ноолууран ээрмэл, 1,360.9* мян.шир сүлжмэл эдлэл үйлдвэрлэжээ.

2020 онд 352,198.5 мян.ам.долларын экспорт хийснээс 76.3% нь угаасан ноолуур, 11.97% нь самнасан ноолуур, 11.82% нь сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн эзлэж байна.

2. НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Төрөөс уул уурхайн бус экспортыг дэмжих, ноолуурын үйлдвэрлэлийн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхээр

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого²,
- “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”³ зэрэг салбарын хөгжлийн урт хугацааны зорилтуудыг тодорхойлсон бол

¹ <https://www.undp.org/mongolia/blog/cashmere-initiatives-working-together-improve-value-chain>

² <https://www.legalinfo.mn/law/details/15406?lawid=15406>

³ <https://www.legalinfo.mn/law/details/13240?lawid=13240>

- “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”⁴-ыг тус тус батлан гаргаж салбарын хөгжлийн дунд хугацааны зорилтуудыг тодорхойлсон.

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол экспорт”⁵ зэрэг хөтөлбөрүүдэд салбарын богино хугацааны зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.

Зураг 2.1. Ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарт төрөөс баримтлах бодлого



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

Ноолуурын үйлдвэрлэлийн салбарын дэмжих, сэргээн хөгжүүлэх, эрхзүйн орчинг сайжруулах чиглэлээр дараах эрхзүйн баримт бичгүүд батлагдаж хэрэгжиж ирлээ. Үүнд:

- Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-ын 2.1.3 дахь хэсэгт аж үйлдвэрийг хөгжүүлэх I үе шат буюу 2016-2020 онд “Нийт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх”;
- Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.50 дахь заалтад “Хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ”;
- Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний 2.1.10 дахь заалтад “Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх гэж; 1.1.8. дахь заалтад Байнгын болон түр ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа аж ахуйн нэгжийг татвар, зээлийн бодлогоор дэмжих гэж тус тус заасан.

⁴ <https://www.legalinfo.mn/law/details/4263?lawid=4263>

⁵ <https://www.legalinfo.mn/law/details/13692?lawid=13692>

- Монгол улсын Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор “Ноолуур” хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ажлын байрыг тогтвортой хадгалах, нэмэгдүүлэх, ноолуурыг чанараар нь ангилж бэлтгэдэг болгох, түүхий эдийн бэлтгэлд зориулсан эргэлтийн хөрөнгийн, техникийн шинэчлэлт болон үйлдвэрлэлийн өргөтгөлд зориулсан хөрөнгө оруулалтын зээлийн нөхцөлийг илүү таатай болгож эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлсэн юм.
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор “Ноолуур” хөтөлбөрийг хүчингүй болгосон.
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 18 дугаар тогтоол, “Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”⁶;
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 178 дугаар тогтоол, “Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай”⁷;
- Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоол, “Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай”

3. НОЛУУРАН ТҮҮХИЙ ЭДИЙН НӨӨЦ

Монгол улс анх 1918 онд малаа тоолж байх үед нийт 9.6 сая толгой малтай байсан бол Улсын хэмжээгээр 2021 оны эцэст, мал тооллогын дүнгээр 67.3 сая толгой мал тоологдож, өмнөх оноос 275.3 мянга (0.4%)-аар өслөө. Үүнээс адуу 4.3 сая, үхэр 5.0 сая, тэмээ 454.0 мянга, хонь 31.1 сая, ямаа 26.5 сая байна. Өмнөх онтой харьцуулахад хонь 1.0 сая (3.5%), үхэр 290.2 мянга (6.1%), адуу 230.6 мянга (5.6%)-аар өссөн бол ямаа 1.3 сая (4.6%), тэмээ 18.9 мянга (4.0%)-аар тус тус буурсан байна⁸.

Хүснэгт 3.1. Малын тоо, төрлөөр, мян.толгой

Он	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1930	23,676.2	1,566.9	1,887.3	480.9	15,660.3	4,080.8
1940	26,204.8	2,358.1	2,722.8	643.4	15,384.2	5,096.3
1950	22,702.2	2,317.0	1,987.8	844.2	12,574.6	4,978.6
1960	23,000.5	2,502.7	1,905.5	859.1	12,101.9	5,631.3
1970	22,574.9	2,317.9	2,107.8	633.5	13,311.7	4,204.0
1980	23,771.4	1,985.4	2,397.1	591.5	14,230.7	4,566.7
1990	25,856.9	2,262.0	2,848.7	537.5	15,083.0	5,125.7
2000	30,227.5	2,660.8	3,097.6	322.9	13,876.3	10,269.8
2010	32,729.5	1,920.3	2,176.0	269.6	14,480.4	13,883.2
2011	36,335.8	2,112.9	2,339.7	280.1	15,668.5	15,934.6
2012	40,920.9	2,330.4	2,584.6	305.8	18,141.4	17,558.7
2013	45,144.3	2,619.4	2,909.5	321.5	20,066.4	19,227.6
2014	51,982.6	2,995.8	3,413.9	349.3	23,214.8	22,008.9
2015	55,979.8	3,295.3	3,780.4	368.0	24,943.1	23,592.9

⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15040>


⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15399>

⁸ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=19._Livestock_2021_I-XII_mn.pdf&ln=Mn

2016	61,549.2	3,635.5	4,080.9	401.3	27,856.6	25,574.9
2017	66,219.0	3,939.8	4,388.5	434.1	30,109.9	27,346.7
2018	66,460.2	3,940.1	4,390.9	459.7	30,554.8	27,124.7
2019	70,969.3	4,214.8	4,753.2	472.4	32,267.3	29,261.7
2020	67,068.5	4,093.9	4,732.0	472.9	30,049.4	27,720.3
2021	67,343.8	4,324.4	5,022.2	454.0	31,087.0	26,456.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

График 3.1. Нийт малын тоонд малын төрөл тус бүрийн эзлэх хувийн жин, 1970-2019 он




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Цаашид мал сүргийн бүтцэд анхаарч тэнцвэртэй тоог баримтлахгүй бол бэлчээрийн даац хэтрэх, бэлчээр сүйдэх зэрэг олон сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй байна. Тухайлбал, ус цаг уур, орчны шинжилгээний газраас жил бүр бэлчээр ашиглалтын нэгдсэн судалгааг хийдэг бөгөөд 2022-2023 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн 23.9% - 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй), 15.6% - 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй), 34.4% - 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн), 7.7% - 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн), 18.4% - 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн) байна. Өөрөөр хэлбэл өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 40 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 60 гаруй хувьд хэтэрсэн байна. Аймгийн дүнгээр авч үзвэл Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймгуудын ихэнх сум, багийн нутгаар даац хэтэрч гарсан байна⁹.

⁹ <https://www.namem.gov.mn/view/3254>

График 3.2. Аймаг болон бүсүүдийн ямааны тоо, 2021 он, мян.толгой



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Ямаан сүргийн тоогоор Хөвсгөл аймаг 2195.8 мянган толгой, Ховд аймаг 1947.3 мянган толгой, Говь-Алтай аймаг 1875.8 мянган толгой, Баянхонгор аймаг 1795.3 мянган толгой, Хэнтий аймаг 1650.4 мянган толгойгоор тэргүүлж байна¹⁰.

Хүснэгт 3.2. Ямааны тоо 2016-2021 он, мян.толгой

Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	25,574.86	27,346.71	27,124.70	29,261.66	27,720.25	26,456.09
Баруун бүс	7,272.68	7,702.37	7,319.93	7,575.66	7,716.26	7,715.20
Завхан	1,310.54	1,352.45	1,292.67	1,418.57	1,338.22	1,329.46
Говь-Алтай	2,173.94	2,356.01	2,196.80	2,269.62	2,123.21	1,875.76
Баян-Өлгий	983.31	971.22	930.40	933.35	1,022.60	1,063.81
Ховд	1,685.86	1,764.77	1,624.60	1,631.32	1,821.98	1,947.26
Увс	1,119.03	1,257.92	1,275.46	1,322.81	1,410.25	1,498.92
Хангайн бүс	9,233.63	9,613.56	9,486.05	10,300.43	8,773.47	8,149.01
Орхон	48.58	40.49	37.98	45.04	52.54	54.85
Өвөрхангай	2,220.54	2,389.22	2,245.81	2,344.61	1,805.61	1,493.50
Булган	1,055.16	1,020.11	1,026.60	1,162.01	1,103.97	1,122.50
Баянхонгор	2,569.12	2,731.79	2,478.90	2,733.70	2,219.20	1,795.32
Архангай	1,402.28	1,435.40	1,499.31	1,708.41	1,489.31	1,486.96
Хөвсгөл	1,937.95	1,996.54	2,197.45	2,306.67	2,102.85	2,195.88
Төвийн бүс	6,075.95	6,619.97	6,672.42	7,515.11	7,370.12	6,617.73
Төв	1,551.26	1,534.16	1,505.97	1,670.55	1,656.76	1,530.10
Говьсүмбэр	177.31	195.08	183.72	194.21	192.44	169.63
Сэлэнгэ	532.04	496.27	519.27	601.60	669.01	635.04
Дорноговь	775.17	893.60	958.59	1,094.61	1,167.70	1,198.08
Дархан-Уул	95.94	92.78	96.97	118.31	129.84	118.38
Өмнөговь	1,555.12	1,773.53	1,691.34	1,983.05	1,887.79	1,593.22
Дундговь	1,389.12	1,634.55	1,716.56	1,852.81	1,666.59	1,373.28

¹⁰ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=19_Livestock_2021_I-XII_mn.pdf&ln=Mn

Зүүн бүс	2,866.31	3,289.78	3,524.72	3,736.22	3,713.98	3,846.46
Дорнод	485.83	592.08	702.08	786.17	810.85	852.68
Сүхбаатар	996.36	1,152.39	1,207.49	1,247.42	1,280.24	1,343.38
Хэнтий	1,384.12	1,545.31	1,615.15	1,702.63	1,622.89	1,650.41
Улаанбаатар	126.29	121.03	121.58	134.24	146.43	127.68

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Ямааны тоогоор Хөвсгөл аймаг 2.2 сая ямаа тус тус тоолуулж улсдаа тэргүүлж байна.

4. НОЛУУРАН ТҮҮХИЙ ЭДИЙН БЭЛТГЭЛ

Ноолуур нь жил бүр нөхөн сэргээгддэг, үндэсний үнэт баялаг бөгөөд ноолуураар нэхмэл, сүлжмэл хувцас, даавуу, хөнжил зэргийг үйлдвэрлэдэг.

Ноолуурын нарийн: 1 микро метрийг 1,000 хуваасны нэгтэй тэнцэх нэгж буюу микроноор ноолуурын диаметрийг хэмжсэн хэмжээг хэлнэ.

Ноолуурын өнгө: цайвар ноолуураар олон төрлийн өнгө гаргаж болдог бол бараан ноолуураар бараан хувцас үйлдвэрлэх боломжтой. Монгол ноолуур ойролцоогоор 60% нь бараан, 15% улаан, 10% саарал, 10% цайвар саарал, 5% цагаан ноолуур бэлтгэгдэж байна.

Ноолуурын бохирдол: ноолууранд буй шороо, хаг, ургамалын хог болон бусад биетийг хэлнэ. Ихэнхи бохирдлыг угааж самнах машинаар арилгана.

Ноолуурын урт: Ноолуур урт байх тусам чанга ээрсэн утас хийж болно. Хялгасыг нь самнасны дараа 42-46мм-ын урттай болдог. Мушгиралдсан ширхэгтэй ноолуур нь удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин зүйл болно.

Ноолуурын гарц: Бохир ноолуур дахь нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрлэлийн шаардлага хангасан хэмжээ юм. 100 кг бохир ноолуураас хялгасыг нь самнасны дараа 50кг ноолуур гарч байвал 50% гарцтай гэсэн үг. Гарц нь ноолууранд буй хялгас, бохирдол, тос болон бусад бохирдлоос шалтгаална.

Дундаж гарц: 45%

Хүснэгт 4.1. 2021 оны ноолуур бэлтгэлийн тооцоо

Аймаг хот	2021 оны ямааны тоо мян.толгой	Ноолуурын гарц, кг	Бэлтгэсэн ноолуурын хэмжээ, тн
Улсын дүн	26,456.09	0.35	9,259.63
Баруун бүс	7,715.20	0.35	2,700.32
Завхан	1,329.46	0.35	465.31
Говь-Алтай	1,875.76	0.35	656.52
Баян-Өлгий	1,063.81	0.35	372.33
Ховд	1,947.26	0.35	681.54
Увс	1,498.92	0.35	524.62
Хангайн бүс	8,149.01	0.35	2,852.15
Орхон	54.85	0.35	19.20
Өвөрхангай	1,493.50	0.35	522.72
Булган	1,122.50	0.35	392.88
Баянхонгор	1,795.32	0.35	628.36
Архангай	1,486.96	0.35	520.44
Хөвсгөл	2,195.88	0.35	768.56
Төвийн бүс	6,617.73	0.35	2,316.21
Төв	1,530.10	0.35	535.54
Говьсүмбэр	169.63	0.35	59.37

Сэлэнгэ	635.04	0.35	222.26
Дорноговь	1,198.08	0.35	419.33
Дархан-Уул	118.38	0.35	41.43
Өмнөговь	1,593.22	0.35	557.63
Дундговь	1,373.28	0.35	480.65
Зүүн бүс	3,846.46	0.35	1,346.26
Дорнод	852.68	0.35	298.44
Сүхбаатар	1,343.38	0.35	470.18
Хэнтий	1,650.41	0.35	577.64
Улаанбаатар	127.68	0.35	44.69

Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

Хүснэгт 4.2. Ноолуур бэлтгэлийн хэмжээ, тн, 2015-2021 он

№	Түүхий эд	2015	2016	2017	2018	2019	2020	2021
1	Ноолуурын нөөц, тн	8,300	9,449.6	9,300	10,000.0	10,000.0	10,800.0	10,100.0
2	Дотоодын үйлдвэрт самнасан ноолуур, тн		776.3	1,101.8	1,160.3	774.0	516.7	511.7
3	Нийт үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь, %		8.2	11.9	11.6	7.74	4.8	5.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

* ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын тооцоолсноор, 2022 он

График 4.1. Ноолуур ашиглалтын харьцаа, мян.тн




Эх сурвалж: Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn, Аж үйлдвэрийн салбарын танилцуулга-2021, https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Industry_2021.pdf&ln=Mn, 27х
ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

5. НООЛУУРАН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Дэлхийн зах зээл дээр ноолуурын үнэ 2018 оны 11 дүгээр сараас унаж, 2020 оны 10 дугаар сараас өссөн байна.

График 5.1. Дэлхийн зах зээл дээрх ноолуурын үнэ



Origin	Date	Index value	VAR.%
China	30/06/2022	144.00	-0.69
Iran	30/06/2022	89.00	0.00
Mongolia	30/06/2022	125.00	-0.80

Эх сурвалж: <https://www.gschneider.com/cashmere-and-silk-market-indicators/>

“COVID-19” цар тахлын улмаас дэлхийн улс орнууд хөл хорио тогтоож, хилээ хаасан бөгөөд манай улс ч хилээ хааж хөл хорио тогтоосон. Энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан БНХАУ болон хилийн чанад руу самнасан ноолуурын тээвэрлэлт хойшлогдсон. Энэ бүх хүчин зүйлүүд нь ноолуурын үнэ буурахад нөлөөлсөн.

<https://www.gschneider.com/-иач> жил бүр эмхэтгэн гаргадаг НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН 2020-д ноолуурын нөөцийн гол тоглогчдийн 2020 оны жилийн үнэ ханш, зэх зээлийн төлөв байдлыг тодорхойлсныг доор харуулав¹¹.

БНХАУ. 2019 он дэлхийн ноолуурын салбарын хувьд хүнд жил байлаа. 2020 оны 2-р сарын дунд үеэс зарим самнах үйлдвэрүүд захиалга авч эхэлсэн боловч COVID-19 тархаж, улмаар дэлхий даяар цар тахал үүссэний улмаас бүх захиалгыг цуцалсан. Өнгөрсөн дөрөвдүгээр сард ноолуурын үнэ нэгдүгээр сартай харьцуулахад 15 орчим хувиар буурсан байна. Үйлдвэрлэл нь 2019 онтой төстэй байсан ч цар тахлын улмаас, ноолуурын эрэлт бүрэн хомсдсоны улмаас үйлдвэрүүд 6-р сарын эхэн хүртэл хаагдахаас өөр аргагүйд хүрчээ.

Хятадад шинэ оны дараа буюу 2019 оны 11, 12-р сард үйлдвэрлэгчид захиалсан захиалгаа үйлдвэрлэж эхэлснээр 3-р сарын эхээр зах зээл бага зэрэг өссөн. Гэсэн хэдий ч 3-р сарын дунд үеэс эхлэн тахал дэлхий даяар тархсаар байсан тул зах зээл огцом унав. Хятад улс цар тахлын улмаас учирсан алдагдлыг бууруулж чадсан тул үйлдвэрүүд банкны зээл авч, татварын хөнгөлөлт эдлэх боломжтой болсон. Гуравдугаар сарын сүүлээр цар тахал, хөл хорио

¹¹ 9. March 2021, [ANNUAL CASHMERE MARKET REPORT 2020](#)

дууссаны дараа засгийн газар хэрэглээг дэмжсэн бодлогыг дэмжиж, орон нутгийн зах зээлийг дэмжихийг хичээв.

Дөрөв, тавдугаар сард ноолуур цуглуулж эхэлснээр Хятадын зах зээл ердөө хоёр долоо хоногийн хугацаанд бэхжсэн. Царт тахлын улмаас олон гол хэрэглээний зах зээл, тэр дундаа АНУ-ын зах зээл бүрэн зогсонги байдалд орсноор ноолуурын экспорт зогссон. 6, 7-р сард ихэнх үйлдвэрлэгчид машин механизмаа зогсоох шаардлагатай болсон. Энэхүү зогсолт нь Spinning компаниудын ажилчдын цалинг өгөхийн тулд машинуудаа ажиллуулахад асуудал үүсгэсэн. Хятадын шинэ оны өмнөх үетэй харьцуулахад ноолууран утаснуудын үнэ 18 орчим хувиар буурсан байна.

Хятадад тахлын хяналт улам бүр нэмэгдэж байгаа тул зарим ээрэх үйлдвэрлэгчид гадаадаас жишээлбэл Энэтхэгээс боловсруулах захиалга авчээ. Ноолуурын утаснуудын бизнес 7, 8-р сард голчлон Монголын ноолуурын хувьд сэргэсэн.

9-р сараас 10-р сар хүртэл дотоодын зах зээл бага зэрэг сайжирсан. Ноолуурын үнэ 5 орчим хувиар бага зэрэг өссөн. Нийтдээ 2020 онд ноолуурын үйлдвэрлэл 2019 онтой харьцуулахад ойролцоогоор 3-5%-иар буурчээ. Гуравдугаар сард ноолуурын үнэ 3-р сард тархаж эхэлснээс хойшхи богино хугацаанд 15 орчим хувиар буурсан байна. Долдугаар сараас арванхоёрдугаар сар хүртэл үнэ 10-15 орчим хувиар өссөн¹².

МОНГОЛ. Монгол Улс “Ноолуурын хөтөлбөр” (2018-2021) хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын ноолуурын үйлдвэрлэлийг 60%-иар нэмэгдүүлж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гадаад зах зээлд гаргах, олон улсын зах зээлд энэ бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд оршино.

Монгол Улсын Засгийн газраас ноолуурын салбарт 2017 онд 188.2 тэрбум, 2019 онд 107.3 тэрбум төгрөгийн жилийн 12-14 хувийн хүүтэй, 2020 онд 300 тэрбум төгрөгийн бага хүүтэй зээлийг жилийн 3-8 хувийн хүүтэй олгож байна. Азийн хөгжлийн банкнаас “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл”-өөс 3 аж ахуйн нэгжид 3.89 тэрбум төгрөг, 2 аж ахуйн нэгжид жилийн 7 хувийн хүүтэй 8.2 тэрбу төгрөгийн санхүүжилт олгосон. Эдгээр хүчин чармайлтыг үл харгалзан тахал нь улс орон, ноолуурын салбарыг бүхэлд нь хүнд байдалд оруулав.

Царт тахлын улмаас Монголын аялал жуулчлалын салбар гадаадаас ирэх бүрэн зогсонги байдалд орсон нь ноолууран хувцасны худалдаанд ихээхэн нөлөөлсөн. Томоохон брэндүүдийн ихэнх захиалгыг цуцалсан.

2020 оны нэгдүгээр сарын сүүлчээс Монгол Улсын хил хаагдсан, зорчих боломжгүй байсан. Монгол, Хятадын худалдаачид сураггүй болсон. Монголоос Хятад руу тайрч, самнасан ноолуурын тээвэрлэлт 30-60 гаруй хоногоор хойшилсон. Эдгээр бүх хүчин зүйлүүд нь өмнөх 2019 онтой харьцуулахад үнэ буурахад нөлөөлсөн. 2009, 2015 оны эдийн засгийн хямралын үед ч түүхий ноолуурын үнэ 25%-30%-иар унасан. Харин 2020 онд түүхий ноолуурын үнэ 40%-иар буурчээ. 2019 онтой харьцуулахад 50%.

Монгол Улс дэлхийн нийт үйлдвэрлэлийн 40 хувийг бүрдүүлдэг. 2020 онд самнасан ноолуурын экспорт 2019 онд 392 тонн байсан бол дөнгөж 215 тоннд хүрч, 2019 онтой харьцуулахад 45 хувиар бага байна. Ноолуурын дийлэнх хувийг Монголд угааж, улмаар Хятад

¹² <https://www.gschnieder.com/annual-cashmere-market-report-2020/>

руу экспортолсон байна. Итали, Их Британи, Герман зэрэг самнасан ноолуурын гол зах зээлүүд тахлын улмаас зах зээлийн эрэлт маш удаан байсан¹³.

ИРАН. Ираны ноолуурын хувьд 2020 он ноолуурын үнэ 2019 оны дунд үеэс 95 орчим доллар байсан бол 2020 оны нэгдүгээр сард 75-80 ам. доллар болж буурснаар эхэлсэн. 2020 онд ийм хямд үнээр дэлхийн эдийн засаг уналт руу шилжиж байгаа юм шиг санагдсан.

Дараа нь тахал гарч, бусад бараг бүх зүйлийн нэгэн адил ноолуурын зах зээл үнэ чөлөөтэй уналтад өртөөд зогсохгүй эрэлтийн огцом хомсдолтой тулгарсан.

Нөгөөтэйгүүр, Иран дахь түүхий эдийн худалдаачид орон нутгийн инфляци маш өндөр, орон нутгийн мөнгөний үнэ тасралтгүй буурч байгаатай холбоотойгоор үнэ огцом өснө гэж найдаж байв. Энэ хүлээлт эрэлт хэрэгцээгүй түүхий ноолуураас бусад бараг бүх бүтээгдэхүүнд биелэв. Удалгүй хэдэн том ноолуурын ченжүүд хувьцаагаа худалдаж авсан үнээсээ хамаагүй доогуур үнээр зарахаас өөр аргагүйд хүрэв. Нэг удаад 18 доллар/кг-аар худалдаж авсан афганы алдартай худалдаачин хэдхэн сарын дотор 10 доллараар заржээ.

2020 оны нэгдүгээр сард Иран ноолуурын үнэ 75-80 ам.доллар орчим байсан. Мөн оны арваннэгдүгээр сард 45-50 орчим үнэтэй байсан. Бараг байхгүй эрэлтийг эс тооцвол 40 орчим хувиар буурсан байна. Түүхий ноолуурын үнэ 1-р сард 12 доллар байсан бол 11-р сард 8 доллар болж, бараг ижил хувиар буурсан байна. Гэвч Хятад руу экспортлох ноолуур цуглуулсан Хятадын худалдаачид болон тэдний Афганистан/Пакистан, Иран агентууд их хэмжээний худалдан авалт хийснээс болж арванхоёрдугаар сард үнэ гэнэт өссөн.

Хааяа Иранаас түүхий ноолуур экспортлохыг хориглосон, эсвэл Хятад руу байгалийн гаралтай түүхий эд импортлохыг хориглосон тухай яриа зах зээлийг хямрааж байсан ч худалдаачид асуудлыг шийдэх арга замыг олох болгонд үнэ дахин нэмэгддэг. Хятадуудын худалдан авалтын улмаас оныг 11 доллар орчим хаасан нь өмнөх сартай харьцуулахад 30%-иар өссөн байна. 2020 онд Ираны түүхий ноолуурын чанар, тоо хэмжээний тухайд өмнөх жилүүдээс чанар сайтай байсан ч албан ёсны статистик мэдээ байхгүй тул тоо хэмжээ нь тодорхойгүй байна. Ердөө 1000 орчим тоннын тэн хагас нь эдийн засгийн хувьд боловсруулахад тохиромжтой, нөгөө тал нь богино урттай, гарц багатай арьс ширний үйлдвэрээс гарсан завод ноолуур юм¹⁴.

Хүснэгт 5.1. Ноолуурын үнэ, төгрөг, 2020-2021 он

Аймаг	Цагаан ноолуур			Цагаан ноолуур		
	2019	2020	2021	2019	2020	2021
Баян-Өлгий	75,625	54,182	108,813	75,625	54,182	108,813
Говь-Алтай	70,190	54,333	95,917	73,593	53,667	92,567
Завхан	80,417	57,600	109,125	80,417	57,333	108,000
Увс	80,800	43,667	109,400	97,667	45,000	116,000
Ховд	75,889	51,286	70,000	52,500	44,400	70,000
Архангай	98,000	49,889	100,000	98,000	51,000	88,571
Баянхонгор	74,583	53,125	108,750	73,750	51,250	106,250
Булган	70,870	44,450	90,000	70,870	44,450	96,000
Өвөрхангай	77,833	56,591	111,375	77,833	69,167	110,750
Хөвсгөл	80,727	48,250	76,000	82,727	55,143	94,571

¹³ <https://www.gschnieder.com/annual-cashmere-market-report-2020/>

¹⁴ <https://www.gschnieder.com/annual-cashmere-market-report-2020/>

Орхон	77,667	54,667	106,444	77,667	54,111	108,500
Дорноговь	84,571	51,000	97,000	93,000	50,333	106,000
Дундговь	92,000	51,300	90,400	92,000	49,000	93,400
Өмнөговь	79,185	56,420	99,333	72,111	52,642	94,333
Сэлэнгэ	85,000	46,667	-	90,667	46,667	117,667
Төв	96,000	52,000	87,500	65,000	44,000	98,750
Дархан-Уул	112,500	58,222	116,667	112,500	58,222	115,000
Говьсүмбэр	100,000	47,500	108,333	-	30,000	-
Дорнод	61,717	50,000	95,000	61,717	50,000	95,000
Сүхбаатар	90,000	61,643	118,333	83,333	61,643	100,000
Хэнтий	88,000	-	88,000	-	-	50,000
Улаанбаатар	79,375	56,667	103,889	79,375	54,464	97,333

Эх сурвалж: Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn, ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

6. НОЛУУРЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Ноолуурын салбарт 2011 оноос хойш 183 аж ахуй нэгж, байгууллагад 726.8 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгоод байна.

Хүснэгт 6.1. Ноолуурын салбарын хөрөнгө оруулалт

Огноо	Эрхзүйн үндэслэл	Зориулалт	Аж ахуй нэгж байгууллагын тоо	Зээлийн хэмжээ, тэрбум төгрөг
2011	ЗГ-ын 221, 368 дугаар тогтоол	Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх	37	98.6
2013	ЗГ-ын 126, 165 дугаар тогтоол	Техник, технологийн шинэчлэл	44	95.3
2014	ЗГ-ын 125 дугаар тогтоол	Эргэлтийн хөрөнгийн зээл	7	29.3
2015	ЗГ-ын 149 дугаар тогтоол	Эргэлтийн хөрөнгийн зээл	8	56.1
2017	Ноолуурын эргэлтийн хөрөнгийг дэмжих	Эргэлтийн хөрөнгийн зээл	9	67.1
2018	Ноолуур хөтөлбөр	Эргэлтийн хөрөнгийн зээл	20	194.4
2019	Ноолуур хөтөлбөр	Эргэлтийн хөрөнгийн зээл	14	82.1
2020	Ноолуур хөтөлбөр, ЗГ-ын 101 дугаар тогтоол	Эргэлтийн хөрөнгийн зээл	44	103.9
2021	ЗГ-ын 42, 59дүгээр тогтоол,	Эргэлтийн хөрөнгийн зээл	38	94.9
	Нийт		221	821.7

ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

7. НОЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ХҮЧИН ЧАДАЛ АШИГЛАЛТ


Төрөөс ноолуурын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхээр урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийг боловсруулж хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, “Ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр угаах үйлдвэрлэл 17.6%, хялгас ялгах үйлдвэрлэл 25.3%, ээрэх үйлдвэрлэл 26.3%, нэхмэлийн үйлдвэрлэл 14.1%, сүлжих үйлдвэрлэл 37.8%-иар тус тус хүчин чадал нэмэгдсэн байна.

График 7.1. Ноолуурын үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал, технологийн дамжлагаар



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

График 7.2. Ноолуурын үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал ашиглалт



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

8. НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Ноолууран ширхэгт нь байгалиас нано бүтэцтэй учраас дээд зэргийн зөөлөн, хөнгөн, дулаан, уян хатан, бөх бат, амьсгалдаг, агаар шүүдэг, галд тэсвэртэй, байгальд задардаг зэрэг хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй үзүүлэлтээрээ ноолууран бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн түвшингийн дундаас дээш болон тансаг хэрэглээний бүлгийнхний хэрэгцээт бүтээгдэхүүн болж, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд эрэлттэй хэвээр байна.

Ноолууран бүтээгдэхүүний гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох угаасан ноолуур 2,235.2 тонн болж 1,389.7 тонн буюу 2.6 дахин өссөн бол самнасан ноолуур 511.7 тонн болж, өмнөх оноос 4.7 тонн буюу 0.9 хувиар, ноолууран ээрмэл 215.0 тонн болж 30.5 тонн буюу 12.4 хувиар тус тус буурчээ.


Хүснэгт 8.1. Ноолуурын салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 2010-2021 он¹⁵

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Угаасан ноолуур /т/		161.6	577.1	771.7	651.0	2,204.1	2,172.5	1,114.0	1,331.8	1,288.5	845.5	2,235.2
Самнасан ноолуур /т/	824.7	874.3	417.	521.8	633.2	754.5	776.3	1,101.8	1,160.3	774.0	516.7	511.7
Ноолууран ээрмэл /т/		212.0	225.0	270.7	314.9	305.4	357.8	425.7	492.1	334.2	245.5	215.0
Сүлжмэл эдлэл /мян.ш/	731.1	757.9	795.1	932.8	954.4	829.3	812.5	1,008.4	1,461.3	1,729.6	1,360.9	

Эх сурвалж: Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Нэг хүнд ногдох самнасан ноолуурын үйлдвэрлэл 2021 онд 0.2 кг болж, 2019, 2020 онтой ижил түвшинд байна.

График 8.1. Нэг хүнд ногдох угаасан ноос, самнасан ноолуур үйлдвэрлэл, килограммаар



Эх сурвалж: Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn, Аж үйлдвэрийн салбарын танилцуулга-2021, https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Industry_2021.pdf&ln=Mn, 27х

9. НОЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЭКСПОРТ

2021 оны байдлаар хагас боловсруулсан ноолууран түүхий эд болон ноолууран сүлжмэл бүтээгдэхүүнийг 35 улс орон руу 352,198.5 мян.ам.долларын экспорт хийжээ.

Хүснэгт 9.1. Ноолууран бүтээгдэхүүний экспорт, улсаар, мянган ам.доллаар

№	Улс орон	Экспортын үнийн дүн, мян.ам.доллар
1	Израиль	1.6
2	Литва	2.7
3	Люксембург	3.9
4	Румын	9.2
5	Шинэ Зеланд	10.8
6	Ирланд	11.8
7	Арабын Нэгдсэн Эмират Улс	12.9
8	Турк Улс	17.0
9	Тайвань	21.9
10	Катар	31.0


¹⁵ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Industry_2021.pdf&ln=Mn

11	Унгар Улс	41.3
12	Норвеги	53.9
13	Дани	70.7
14	Испани	71.8
15	Чех улс	87.1
16	Португал	93.4
17	Бельги	100.0
18	Непал	113.0
19	Украйн	121.7
20	Польш	164.5
21	Канад	189.2
22	Швед	191.5
23	Хонконг	197.0
24	Казахстан	269.6
25	Австри	425.0
26	Нидерланд	1,838.0
27	Япон	3,260.5
28	Франц	4,310.3
29	Америкийн Нэгдсэн Улс	4,426.7
30	ОХУ	4,823.8
31	ХБНГУ	7,177.4
32	БНСУ	7,617.3
33	Их британи	9,508.6
34	Итали	30,537.9
35	БНХАУ	276,385.7
	БҮГД	352,198.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021,
<https://gaali.mn/statistic/news/6260fefaf35d25a6c7a0ce962>

БНХАУ ноолуурын экспортын 78%-ийг, Нидерланд 9%-ийг, Их Британи 3%-ийг, БНСУ 2%-ийг, ХБНГУ 2%-ийг, ОХУ 1%, АНУ 1%, Франц 1%, Япон 1%, Нидерланд 1%, бусад улс орнууд нийлээд 1%-ийг эзлэж байна.

График 9.1. Ноолуурын экспорт, улс орноор, хувиар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021,
<https://gaali.mn/statistic/news/6260fefaf35d25a6c7a0ce962>

2021 онд 275,615.3 мян.ам.долларын үнэ бүхий 9,055.1 тн угаасан ноолуур, 39,923.0 мян.ам долларын үнэ бүхий 424.0 тн самнасан ноолуур экспортолжээ.

Хүснэгт 9.2. Ноолууран бүтээгдэхүүний экспорт, улсаар, мянган ам.доллороор

Боловсруулалтын түвшин	Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	2021 он		Экспортод эзлэх хувь, %
				Тоо	Үнэ	
Угаасан ноолуур	51021120	Ямааны угаасан ноолуур	кг	6,026,852.20	253,646.4	
		Америкийн Нэгдсэн Улс		10.60	0.5	
		БНХАУ		6,026,841.60	253,645.8	
	51021142	Ямааны завод ноос ноолуурын агууламж нь 22.0 %-аас их	кг	2,936,144.30	21,893.3	
		БНХАУ		2,936,144.30	21,893.3	
	51032011	Ямааны ноолууран сэв хялгас.Ноолуурын агууламж нь 12 хувь буюу түүнээс бага	кг	55,387.40	15.5	
		БНХАУ		45,000.00	11.3	
		ОХУ		10,387.40	4.2	
	51032012	Ямааны ноолууран сэв хялгас.Ноолуурын агууламж нь 12 хувиас их	кг	36,665.00	60.1	
		Итали		4,706.20	47.3	
ОХУ			31,958.80	12.7		
		Нийт дүн		9,055,048.90	275,615.30	
Самнасан ноолуур	51053110	Ямааны самнасан ноолуур	кг	423,979.80	39,923.0	
		БНСУ		16,800.00	1,834.4	
		БНХАУ		26,820.00	868.5	
		Испани		150.00	22.2	
		Итали		296,830.90	29,290.2	
		Их британи		60,956.20	5,986.9	
		Непал		31.00	3.7	
		Франц		137.90	14.2	
		ХБНГУ		18,105.30	1,458.0	
		Швейцар		1,423.50	145.3	
		Энэтхэг		1,600.00	168.0	
		Япон		1,125.00	131.6	
				Нийт дүн		423,979.80
Дахин боловсруулсан ноолуур	51053130	Дахин боловсруулсан богино ноолуур	кг	1,014.90	9.2	
		Швейцар		1,014.90	9.2	
		Нийт дүн		1,014.90	9.2	
		НИЙТ		9,480,043.60	315,547.50	100%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021, <https://gaali.mn/statistic/news/6260fefa35d25a6c7a0ce962>

2021 онд угаасан ноолуурын 99.9 хувийг БНХАУ-д экспортолжээ. Самнасан ноолуурын экспортын хэмжээ 2021 онд 424 тн болж, өмнөх оноос биет хэмжээ 164.0 (63.1%) тонноор, үнийн дүн 23,046.0 (136.6%) мян.ам.доллороор тус тус өсчээ. Самнасан ноолуурын 70 хувийг Итали улсад, 14.4 хувийг Их Британи улсад, 6.3 хувийг БНХАУ-д, 4.3 хувийг ХБНГУ-д, 4.0 хувийг БНСУ-д, үлдэснийг бусад улс орнууд руу экспортолжээ.

Хүснэгт 9.3. Ноолууран бүтээгдэхүүний экспорт, улсаар, мянган ам.доллороор, 2018-2021 он

Нэр төрөл	2018		2019		2020		2021	
	Тоо /тн/	Үнэ	Тоо /тн/	Үнэ	Тоо /тн/	Үнэ	Тоо /тн/	Үнэ
Угаасан ноолуур	5,286.6	2551,956.2	5,688.7	283,289.7	6,339.8	185,312.2	6,026.9	253,646.4
БНХАУ	5,286.6	2551,956.2	5,688.7	283,289.7	6,339.8	185,312.2	6,026.8	253,645.8
Бусад					0.0	0.9	0.0	0.5
Самнасан ноолуур	630.2	54,944.2	507.2	45,319.3	260.0	16,877.0	424.0	39,923.0
БНСУ	0.2	17.0	10.1	960.9	12.7	1,037.4	16.8	1,834.4
БНХАУ							26.8	868.5
Итали	522.6	46,656.9	422.0	38,542.9	210.4	13,629.1	296.8	29,290.2
Их Британи	50.5	4,807.1	45.3	4,472.3	16.8	1,126.0	61.0	5,986.9
Энэтхэг	7.4	720.3	5.1	491.6	6.1	472.5	1.6	168.0
Япон	1.4	96.5	0.3	29.1	-	-	1.1	131.6
ХБНГУ							18.1	1,458.0
Бусад	48.1	2,646.4	24.4	822.5	14.1	612.0	1.8	185.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021,
<https://gaali.mn/statistic/news/6260fefaf35d25a6c7a0ce962>

Нийт ноолууран бүтээгдэхүүний экспортын 76.3% нь угаасан ноолуур, 11.97% нь самнасан ноолуур, 11.82% нь сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн эзлэж байна.

Хүснэгт 9.4. Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын экспорт, мян.ам.доллар

Нэмүү өртгийн сүлжээ	Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	Экспорт				Импорт				Экспортод эзлэх хувь, %
				2020 он		2021 он		2020 он		2021 он		
				Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	
Угаасан ноолуур	51021110	Ямааны угаагаагүй ноолуур	кг	0	0	0	0	22,271.0	5.8	16,050.8	53.6	76.3%
	51021120	Ямааны угаасан ноолуур	кг	6,339,831.4	185,313.1	6,026,852.2	253,646.4	19,306.2	427.0	116,699.1	5,322.8	
		Нийт			185,313.1		253,646.4		427.0		5,322.8	
Самнасан ноолуур	51053110	Ямааны самнасан ноолуур	кг	259,999.0	16,877.0	423,979.8	39,923.0	0	0	0	0	11.97%
		Нийт			16,877.0		39,923.0		0		0	
Дахин боловсруулсан ноолуур	51053130	Дахин боловсруулсан богино ноолуур	кг	96.0	.9	1,014.9	9.2	0	0	0	0	0.003%
		Нийт			0.9		9.2		0		0	
Сүлжмэл бүтээгдэхүүн	6101	Сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эр)	ш	425.0	77.6	331.0	121.7	5,082.0	131.1	9,933.0	253.2	11.82%
	6102	Сүлжмэл пальто, цув, дулаан хүрэм (эм)	ш	14,696.0	1,503.9	13,667.0	1,725.1	21,276.0	186.6	18,177.0	349.5	
	6103	Сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон (эр)	-	0	986.5	0	483.2	0	575.3	0	858.4	
	6104	Сүлжмэл костюм, ансамбль, хантааз, платъя, банзал, өмд, комбинзон (эм)	-	0	3,043.5	0	3,444.9	0	1,280.7	0	1,674.4	
	6105	Сүлжмэл дотуур цамц (эр)	ш	47,865.0	3,027.3	26,010.0	1,554.1	43,892.0	388.2	91,029.0	539.4	
	6106	Сүлжмэл дотуур цамц (эм)	ш	135,585.0	7,440.3	131,395.0	7,321.8	42,794.0	232.8	66,941.0	296.6	
	6107	Сүлжмэл дотуур хувцас (эр)	ш	178.0	11.8	30.0	2.5	195,231.0	350.4	229,439.0	491.6	
	6108	Сүлжмэл дотуур хувцас (эм)	ш	729.0	67.5	2,622.0	115.2	311,790.0	687.0	442,101.0	834.4	
	6109	Сүлжмэл футболка, майк	ш	9,546.0	266.6	9,232.0	402.8	962,853.0	2,648.2	1,392,800.0	3,460.0	
	6110	Свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамц	ш	291,498.0	14,088.7	290,128.0	15,037.3	257,526.0	2,786.0	335,272.0	3,150.0	

	6111	Хүүхдийн сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэглэл	ш	3,212.0	59.7	2,073.0	44.2	105,845.0	388.4	124,328.0	479.9	
	6114	Сүлжмэл бусад хувцас	ш	2,888.0	16.5	4,518.0	33.4	24,542.0	102.8	89,185.0	226.5	
	6115	Сүлжмэл оймс, оймсон зүйлс	-	0	2,464.3	0	3,155.7	0	1,190.3	0	1,618.0	
	6116	Сүлжмэл бээлий, ханцуйвч	хос	223,093.0	575.1	435,078.0	1,721.9	6,382,166.0	1,163.2	10,485,118.0	1,489.7	
	6117	Хувцасны сүлжмэл бэлэн эд анги, тоног хэрэглэл	ш	235,777.0	3,558.2	368,279.0	4,262.1	1,043,680.0	978.3	1,741,228.0	155.5	
		Нийт			37,187.5		39,425.9		13,089.3		15,877.1	
Нэхмэл бүтээгдэхүүн	63012010	Ямааны ноолууран хөнжил	ш	6,944.0	673.9	5,551.0	591.0	.0	.0	8.0	.6	0.18%
		Нийт			673.9		591.0		.0		.6	
		НИЙТ ДҮН			240,052.4		333,595.5		13,522.1		21,254.1	100%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021, <https://gaali.mn/statistic/news/6260fefaf35d25a6c7a0ce962>

БОЛОВСРУУЛСАН: Б.Эрхэмбаяр, ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн



© Энэхүү материалыг ХХААХҮЯ-ны тусгай зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр хувиан олшруулах, ашиглахыг хориглоно.